

**СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГА, БАГШИЙН  
АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭГ ЗОХИОН БАЙГУУЛСАН АЖЛЫН ТАЙЛАН.  
(ДОРНОД АЙМАГ)**

2024 оны 04 сар 22 өдөр

Дорнод аймаг

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2024 оны 03 дугаар сарын 11 өдрийн А/115 тоот тушаалын нэгдүгээр хавсралт “Цэцэрлэгийн багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлэх, дүгнэх журам”, Боловсролын үнэлгээний төвийн захирлын 2024 оны 04 дүгээр сарын 01 өдрийн 01/139 тоот албан бичгийн хоёрдугаар хавсралт “Сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллага, багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээг цэцэрлэгийн түвшинд зохион байгуулах удирдамж”-ийг тус тус үндэслэн Дорнод аймгийн сургуулийн өмнөх боловсролын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээг 04 сарын 15-19 өдрүүдэд орон нутгийн түвшинд зохион байгууллаа.

Нэг: Ерөнхий мэдээлэл

Боловсрол, шинжлэх ухааны газрын даргын А/18 тоот тушаалаар 32 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг, хоёрдугаар хавсралтаар Боловсрол, шинжлэх ухааны газрын арга зүйч, цэцэрлэгийн эрхлэгч, ерөнхий боловсролын сургуулийн сургалтын менежерээс бүрдсэн 36 хүний бүрэлдэхүүнтэй хөндлөнгийн комиссыг томилсон бөгөөд ажлын хэсгээс 11 чиглэл бүхий ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн үнэлгээг зохион байгуулахад баримтлах 10 чиглэл бүхий дэг, үнэлгээний болон хөндлөнгийн комисст зориулсан зөвлөмжийг боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллав.

Боловсролын үнэлгээний төвөөс тус аймгийн хэмжээнд үнэлгээг зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнд НБГ-ын мэргэжилтэн Н.Оюунсүрэн, БСҮХ-ын мэргэжилтэн Н.Ундармаа нар томилогдон ажиллалаа.

Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын болон багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд төрийн өмчийн 31 цэцэрлэгийн 208 багш хамрагдсанаас бүлгийн багш 189, хөгжмийн багш 14, биеийн тамирын багш 3, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилладаг 2 багш хамрагдсан байна.

Багшийн гүйцэтгэлийнд 226 бүлгийн 3707 буюу нийт хүүхдийн 56,4% сонгогдон баталгаажсан бөгөөд гүйцэтгэлээр авч үзвэл 3383 хүүхэд үнэлгээнд орж өвчтэй 152, чөлөөтэй-125 тасалсан 47 байлаа.

ХОЁР: ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ ЗОХИОН БАЙГУУЛСАН ЯВЦЫН МЭДЭЭЛЭЛ:

**2024 оны 04 сарын 15 өдөр**

Боловсролын үнэлгээний төвөөс томилогдсон ажлын хэсэг 04 сарын 15-ний өдрийн 08.00-09.00 цагт бэлтгэл ажил, явцын талаар орон нутгийн ажлын хэсэгтэй уулзан санал солилцож, 09.00-10.30 цагт үнэлгээний багт үнэлгээг хэрхэн зохион байгуулах талаар мэдээлэл, уулзалт зохион байгууллаа. Уулзалтад 31 цэцэрлэгийн эрхлэгч, арга зүйч нийт 63 хүн оролцов.

Тус өдөр Хэрлэн сумын нийт 18 цэцэрлэгээр орж бэлтгэл ажилтай танилцан биечлэн зөвлөгөө өгсөнөөс гадна, 17.00-17.30 бүх үнэлгээний багт бэлтгэл ажилтай танилцах явцад гарсан анхаарах асуудлаар чиглүүлэг зөвлөгөө өглөө.

## 2024 оны 04 сарын 16-ны өдөр

БҮТ-өөс томилогдсон комисс болон аймгийн ажлын хэсэг хамтран Хэрлэн 5, 3, 11,16, 8, 10,14, 15, 12, шинэ-хөгжил, цэцэрлэгээр орж бага бүлгийн хүүхдийн үнэлгээний зохион байгуулалт болон эцэг эхийн санал асуулгад оролцож байгаа явцтай танилцаж зөвлөгөө чиглэл өгсөн. Аймгийн ажлын хэсгээс гаргасан төлөвлөгөөний дагуу 17.30-18.00 цагт онлайн уулзалт зохион байгуулж Халхгол, Баян-уул сумын цэцэрлэгийн салбар бүлэг Хэрлэн сумын 11, 12 дугаар цэцэрлэгийн бага бүлгийн үнэлгээг зохион байгуулсан тухай явцын талаар мэдээлэл сонссон.

## 2024 оны 04 дүгээр сарын 17 өдөр

Дунд бүлгийн багшийн үнэлгээгээр ажлын хэсэг хуваарийн дагуу 3 хуваагдан хуваарьт цэцэрлэгийн үнэлгээний явцтай танилцахаас гадна байгууллагын орчны үнэлгээ хийж баталгаажууллаа. Үнэлгээний явцад хүүхдийн оноо, баталгаажуулалт тэмдэглэлийг тулган үзэх, эцэг эхийн санал асуулгын зохион байгуулалттай танилцаж газар дээр нь зөвлөгөө өгсөн.

## 2024 оны 04 дүгээр сарын 18 өдөр

Ахлах бүлгийн багшийн үнэлгээгээр аймгийн төвөөс 50 км алслагдсан Булган сумын цэцэрлэгийн үнэлгээний явцтай танилцлаа. Цэцэрлэгийн гүйцэтгэлийн үнэлгээний талаар сумын удирдлага, эцэг эхчүүд бүрэн мэдээлэлтэй байсан бөгөөд үнэлгээнд хөндлөнгийн ажиглагчаар ЕБС-ийн сургалтын менежер, соёлын төвийн эрхлэгч нар хяналт хийж ажиллаж байсан. Мөн өдөр Хэрлэн сумын 10, 8, 2, 9, 14 дүгээр цэцэрлэгүүдэд очиж үнэлгээний явцад хяналт тавьсан. Үдийн дараа 17.30-18.00 цагт аймгийн ажлын хэсгийн ахлагч Б.Бямбаханд үнэлгээний баталгаажуулалт болон цаашид анхаарах асуудлыг талаар мэдээлэл хийж чиглэл өглөө.

## 2024 оны 04 дүгээр сарын 19 өдөр

Бэлтгэл бүлгийн багшийн үнэлгээгээр Хэрлэн сумын 3-р цэцэрлэгийн тусгай бүлэг, 5, 18, 12 -р цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн үнэлгээний явцтай танилцсан.Үнэлгээ хэвийн хүүхэд, эцэг эхийн оролцоо идэвхтэй сайн байлаа. Оройны 17.30-18.30 цагт онлайн уулзалт зохион байгуулж үнэлгээний зохион байгуулалт, түүнтэй холбоотой засан сайжруулалт, тулгамдсан асуудлаар санал солилцлоо.

### Цаашид анхаарах дараах асуудал байгааг үнэлгээний багийн гишүүд хэллээ:

- Үнэлгээний даалгаврыг урд орой нь эсвэл үнэлгээ эхлэхээс 3 цагийн өмнө (07.00) өгөх, багш даалгавартай бүрэн танилцах боломж олгох;
- Даалгаврыг засваргүйгээр нэг мөсөн оруулах;
- Бага бүлгийн даалгавар математикийн энгийн төсөөлөлийн 1.2-ийн чадвар хүндэвтэр байсан;
- Системийг сайжруулж улам боловсронгуй болгох;
- Урьдчилан туршилт хийх;
- Асуудлыг тухай бүр шийдэж байх;
- Үнэлгээний даалгавруудын тоо арай олон байгаагаас цаг хугацаа нилээн шаардагдаж мөн хүүхдүүд залхах шинжтэй болж ирсэн. Нэг даалгавар дээр байх интеграц нь 2-оос хэтрэхгүй байх

4-р сарын 15-19 нд явагдсан үнэлгээний явцад үүссэн асуудал, түүнийг шийдвэрлэсэн байдлыг цэцэрлэг бүрээр авч үзвэл:

### Хүснэгт 1

1-р цэцэрлэг	Бага бүлгийн 3 хүүхдийн эцэг эх асуулганд орж чадахгүй түүвэрт хамрагдаагүй гэсэн үг гарч орж чадахгүй байна энэ асуудлыг 3 удаа Бямбаханд багшид утсаар мэдэгдэн алдааг зассан.
2-р цэцэрлэг	Ахлах б бүлгийн 2 хүүхдийн эцэг эх асуулгадаа орж чадахгүй хамрагдаагүй. Бүртгэлттэй

	утас нь код ирээгүй. Бямбаханд багшид утсаар мэдэгдсэн. Бага Б 2 хүүхэд өвчтэй, Дунд Б бүлэгт 2 хүүхэд өвчтэй гэсэн эмчийн магадлагаатай тул үнэлгээнд хамрагдаж чадаагүй.
3-р цэцэрлэг	Зөрчил асуудал үүсээгүй.
4-р цэцэрлэг	Зөрчил асуудал үүсээгүй.
5-р цэцэрлэг	Үүссэн асуудал байхгүй
6-р цэцэрлэг	Дунд бүлгийн 4 настай Аутизмтай 1 хүүхдийг Хөндлөнгийн комиссын хуралдаанаар эмчийн онош магадлагааг үндэслэн үнэлгээнд оруулахгүй шийдвэр гарсан
7-р цэцэрлэг	Ямар нэгэн зөрчил асуудал гараагүй.
8-р цэцэрлэг	Үнэлгээнд Хөгжлийн танхимын 2 багш оролцсон. Нийт 14 багш үнэлгээнд оролцож байна. Ахлах бүлгийн 1 хүүхдийн эцэг эх аппликейшний дугаартай тул асуулгад оролцож чадаагүй.
9-р цэцэрлэг	эцэг эхийн утасны дугаар буруу бүртгэгдсэн- 2 тохиолдол
10-р цэцэрлэг	Ахлах бүлгийн 1 хүүхдийн эцэг эх сүлжээгүй газар байгаа тул хамрагдаагүй.
11-р цэцэрлэг	Асуудал зөрчил үүсээгүй
12-р цэцэрлэг	Асуудал зөрчил үүсээгүй
14-р цэцэрлэг	Асуудал зөрчил үүсээгүй
15-р цэцэрлэг	Ямар нэгэн асуудал гараагүй болно.
16-р цэцэрлэг	Эцэг эхийн асуулгад 3 хүн оролцоогүй. 1 эцэг эхийн утасны дугаар ашиглалтад байхгүй, 1 эцэг эхийн утасны дугаарын эрх дууссан сунгах боломжгүй зарагдсан. 1 эцэг эх нь гадагшаа ажлаар явсан дуудлага хүлээн авах боломжгүй .
17-р цэцэрлэг	1 хүүхдийн аав хагалгаанд орохоор Турк улсруу явсан байсан. Мессеж руминг үйлчилгээ идэвхжүүлэн асуулгад хамрагдсан.
18-р цэцэрлэг	Асуудал зөрчил үүсээгүй болно.
Шинэ-хөгжил	Асуудал үүсээгүй
Баяндун	Ахлах бүлгийн багшийн даалгавар 4-т болно гэснийг + тэмдэгээр тэмдэглэхийг хүүхдүүд зөв тэмдэглэгээгээр тэмдэглэж байсан.Тэмдэглэгээ зөрүүтэй ч зөв тэмдэглэсэн бол харгалзах оноог нь өгч ажиллахаар шийдвэрлэсэнДунд, ахлах, бэлтгэл бүлгүүдэд заагдаагүй дуу ирсэн тул багшаас заагдсан дууны жагсаалт авсан.Үнэлгээний багаар ярилцаад Дунд бүлэгт “Бүгдийг чадна би би”, “Амин хүү дэ би”, ахлах бүлэгт “Бүгдийг чадна би би”, “Яагаад”, Бэлтгэл бүлэгт “Алтанзул” дууг сонгосож даалгавар гүйцэтгүүлэхээр шийдвэрлэв.
Баян-Уул	Эцэг эхчүүд бүртгүүлсэн дугаараа сольсон, хөдөө утас нь холбогдохгүй, утсан дээр код ирсэн ч нэвтэрч болохгүй гэсэн асуудлууд тулгарч байсан. Хөгжим дээр ахлах, бэлтгэл бүлэгт сонгогдсон дуулах дуу нь тухайн бүлэгт заагдаагүй байсан тул үнэлгээний багаараа ярилцаад дууг тухайн 2 бүлэгт үзсэн дуунаас нь сонгосон.
Баянтүмэн	Дунд бүлгийн эцэг эхийн асуулгад 3 хүн хамрагдаж чадаагүй / 2 хүний дугаар солигдсон, 1 хүн холбогдох боломжгүй /
Булган	нийт 65 хүүхэд түүвэрт сонгогдсноос 54 хүүхэд үнэлгээнд хамрагдаж, 4хүүхэд өвчтэй, 4хүүхэд хүндэтгэн үзэх шалтгаантай,3хүүхэд тасалсан.бэцэг эх утасны дугаараа сольсон учир хамрагдаагүй
Гурванзагал	Дунд бүлгийн нэг хүүхэд ар гэрийн асуудалтай чөлөөтэй, бэлтгэл бүлгийн нэг хүүхэд өвчтэй байсан учир үнэлгээнд хамрагдаагүй. Өөр асуудал зөрчил үгүй.
Дашбалбар	Зөрчил дутагдал гараагүй
Матад	Зөрчил дутагдал гараагүй Асуудал үүсээгүй
Сэргэлэн	Нэг хүүхдийн эцэг эх санал асуулгад оролцоогүй.( утас солигдсон )
Халхгол	Шилжилт хөдөлгөөн 2 хүүхэд шилжсэн. Өвчтэй 4 чөлөөтэй 2 хүүхэд байсан. Бэлтгэл бүлгийн эцэг эх дугаар сольсон учир эцэг эх, багшийн асуулгад оролцож чадаагүй.
Хөлөнбуйр	Ямар нэгэн зөрчил гараагүй.
Цагаан-овоо	Ахлах бүлгийн Мөнхнавчийн эцэг эхийн асуулганаас багшийн үнэлгээг нээхэд бөглөсөн төлөвтэй байсан, нийт 8 асран хамгаалагч утасны дугаар сольсон, хөдөө сүлжээгүй газар байгаад асуулгад хамрагдаагүй, бусад ажлууд хэвийн сайн.
Чойбалсан	Ямар нэгэн зөрчил гараагүй
Чулуунхороот	Дунд бүлгийн 1 хүүхэд өвчтэй, 1хүүхэд нь сумын төвд харах хүнгүй энэ хичээлийн жилийг амартал цэцэрлэгт хамруулах боломжгүй гэсэн шалтгаанаар чөлөө авсан, бэлтгэл бүлгийн 2 хүүхэд хот руу эмчилгээнд явсан акттай, 1 хүүхэд Дорнодын хувийн цэцэрлэг рүү шилжсэн. Нийт 2 бүлгийн 5 Хүүхэд үнэлгээнд хамрагдаагүй. Өөр асуудал зөрчил гараагүй.

Тайлан бичсэн: Ажлын хэсгийн нарийн бичиг

Д.Өнөрцэцэг

Хянасан: Ажлын хэсгийн ахлагч Б.Бямбаханд

# ХАВСРАЛТ

